



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 328

Улаанбаатар хот

### Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.5, 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 175 дугаар тогтоолоор баталсан “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-д үнэт цаасны зах зээлд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.

2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК /Г.Ганзориг/, “Голомт банк” ХХК /Г.Ганболд/-д тус тус үүрэг болгосугай:

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэргэжлийн үйл ажиллагааны болон ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөж, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу ажиллах;

2/ Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хадгалж, холбогдох хууль журамд заасан кастодианы үйлчилгээг үзүүлж ажиллах;

3/ Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН